

Дархан сумын сургууль - Эл Салвадор,
 Эл Салвадорын Америк сургууль
Баяндэлгэр сумын сургууль - Словика,
 Максимилиан Хилл сургууль
Баянжаргалан сумын сургууль - АНУ,
 Фернвүүд Монтесори сургууль
Халзан сумын сургууль - Монгол
 улс, Баян Өлгий аймгийн Zayed-ийн
 нэрэмжит сургууль

Сургуулиуд хоорондын идэвхитэй харилцааны үр дүнд зарим сургуулиуд холбоо тогтоож буй Монгол сургуулийн хүнд асуудлыг шийдвэрлэж, гар сунган хамтран ажиллаж байна. Үүний жишээ бол Английн Уэльс мужийн Глинкойд бага сургуулийн багш, сурагчдын сайхан сэтгэл, идэвхи санаачлагатай ажилласны үр дүнд Төв аймгийн Баян сумын сургууль интернеттэй болж, багш, сурагчид хоорондоо чөлөөтэй харилцдаг болсон.

Сургууль хоорондын харилцааны хөтөлбөрт хамрагдсан ангийн сурагчдаар байгаль хамгаалал, хиймэл үүрний ач холбогдол, идлэг шонхорын идэш тэжээл зэрэг өргөн хүрээтэй сэдвийн дор зураг зуруулсан нь хүүхдүүдэд олон талын ач холбогдолтой ажил боллоо. Хөтөлбөрт хамрагдсан 20 сургуулиас ирүүлсэн хүүхдүүдийн шилдэг бүтээлүүдийг ашиглан сурталчилгааны календар хэвлүүлж хөтөлбөрт хамрагдсан сумдын айл өрхөөр тарааж байгаа нь хиймэл үүрний ач холбогдлыг ард иргэдийн дунд ойлгуулахад чухал түлхэц болж байна. Мөн жилд 2 удаа “Сургууль хоорондын харилцааны хөтөлбөр”-ийн сонин гарган тараадаг. Бид 2015 онд олон багц хичээл болон бусад ажлуудыг боловсруулж сурагчдад хүргэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Та бүхэн манай хөтөлбөртэй холбоотой мэдээллийг Монгол болон Англи хэл дээр дараах холбоос руу (www.schoollinksprogramme.org) орж дэлгэрэнгүй мэдээлэл авч болно.

И.Сарангэрэл, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв

Монголд анх удаа тогорууны баяр тэмдэглэлээ

Дэлхийн олон улс орнуудад жил бүр Тогорууны баяр зохион байгуулагддаг. Энэ баярын үеэр хүмүүс энэхүү үзэсгэлэнт шувуудыг харан баясахаас гадна, тогоруу болон тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах үйлсэд дуу хоолойгоо нэгтгэх боломж бүрддэг байна.

Энэ жил Монголд анх удаа Тогорууны баярыг зургаадугаар сарын 13-ны өдөр Хэнтий аймгийн Биндэр суманд амжилттай зохион байгууллаа. Уг баяр наадмыг Олон улсын тогорууны сан болон Зэрлэг амьтан судлах хамгаалах төвөөс санаачлан БОНХЯ, Биндэр сумын ЗДТГ, ИТХ, Дэлхийн Байгаль Хамгаалах Сан, Онон-Балжийн БЦГ, Хан Хэнтийн ДЦГ, GeoEx компани болон бусад олон байгууллагуудын дэмжлэгтэйгээр амжилттай болж өнгөрлөө.

Тогорууны баяр зохион байгуулагдаж буйн гол зорилго нь Монгол болон дэлхийн хэмжээнд ховордож байгаа цэн тогоруу, мөн ус намгархаг газрын хамгааллын тухай нутгийн иргэдийн ойлголтыг сайжруулахад оршино.



Тус баярын үеэр байгаль орчин, ус намгархаг газрын хамгааллын үндэс, ховор зүйлийн тогоруунууд болон тэдгээрийг хамгаалах асуудлууд, байгаль орчны холбогдох хууль тогтоомжууд, мөн Хурхын хөндийд хийгдэж буй цэн тогорууны судалгааны тухай цогц мэдээллүүдийг байгаль хамгаалал, шувуу судлалын чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагууд нутгийн иргэдэд хүргэлээ. Үүний зэрэгцээ Монгол түмний минь уламжлал болсон үндэсний бөх, сур харваа, хурдан морины уралдаан болж хурсан олныг хөгжөөн баясгав.

Энэ удаагийн баярын онцлох үйл явдлаар Биндэр сумын сурагчид буриад бүжиг бүжиглэж, «Цэн тогоруугаа хамгаалъя» сэдэв дор АНУ-ын алдарт “The Muppet Show” хамтлагийн жүжигчид Heather Henson, Elizabeth Smith нар утсан хүүхэлдэйн тоглолт, Онон-Балжийн БЦГ-ын багш, сурагчид өөрсдийн бэлдсэн цэн тогоруу жүжигчилсэн тоглолт зэргийг толилуулсан нь иргэдэд ихээр таалагдлаа. Үүний зэрэгцээ Зэрлэг амьтан

судлах хамгаалах төв нь Heather Henson болон Монголын драмын театрга хамтран зургаадугаар сарын 22 өдөр тус театрт асрамжийн газрын 100 хүүхэд болон бусад хүүхдүүд, эцэг эхчүүдэд “Тогоруу ба нар” сэдэвт утсан хүүхэлдэйн тоглолтыг толилуулсанаас гадна Монгол орны тогоруу, хамгааллын талаар танин мэдэхүйн мэдээллийг хуран цугларсан хүмүүст хүргэлээ. Ийнхүү анх удаагийнх гэхэд олон арга хэмжээ, баяр наадам, тоглолтууд, мэдээллүүдийг олон хүмүүст хүргэсэн өргөн дэлгэр Тогорууны баяр болж өнгөрлөө.

И.Сарангэрэл, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв

Монголын шувуу ажиглагчдын клуб

Монголын шувуу ажиглагчдын клуб (МШАК) нь Монголынхоо ард иргэд, залуучууд, хvхэд багачуудад шувуудыг таниулах, байгаль дахь ач холбогдлыг нь ойлгуулах, шувуу ажиглагч, сонирхогчдын тоог өсгөх зорилгоор Зэрлэг амьтан судлах хамгаалах төвийн дэргэд 2008 оны хавар байгуулагдсан. Өнгөрсөн хугацаанд клубээс хүүхэд залуусын дунд олон арга хэмжээ зохион байгууллаа. Бид дунд сургуулийн сурагчдад зориулан «Хврээлэн буй орчин ба шувууд», «Шувуудаа таньж мэдэхийн ач холбогдол», «Шувуу хэрхэн ажиглах вэ?» «Шувууд ба багачууд» зэрэг сэдвүүдээр илтгэл, семинар, өдөрлөг зохион байгуулдаг. Мөн Дэлхийн нүүдлийн шувуудын өдрийг сүүлийн 3 жил тогтмол зохион байгуулж байна.

МШАК нь гишүүнчлэлтэй (нээлттэй, үнэ төлбөргүй) бөгөөд клубын Facebook group одоогоор 1600 гаруй гишүүнтэй болж байгаль хамгаалал болон Монгол орны шувуудын талаарх мэдлэг мэдээллийг ард түмэнд тогтмол хүргэж, мөн энэ группээрээ дамжуулан жил бүр Монголын шувуу ажиглагч, сонирхогчдын уулзалтыг зохион байгуулж байна. Саяхан буюу 2014 оны хавар Өмнөговь аймгийн төв дээр манай клубын хөдөө орон нутаг дахь анхны салбар нээгдлээ.

МШАК блог хуудсандаа өөрсдийн зохион байгуулж буй ажлуудаас байнга нийтлэж олон нийтэд хүргэхээс гадна гишүүдийнхээ шувуу ажигласан аяллын тэмдэглэлүүдийг нийтлэдэг. Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг манай блоогоос үзнэ үү: <http://www.mongolbirdwatchclub.blogspot.com/>.

Клубын блог дээр 2008 оноос хойш Монгол орны шувуудын талаар болон өөрсдийн хийж буй ажлын талаар нийтдээ 150 гаруй нийтлэл тавигдсан ба манай клубын блог руу хандсан хандалтын тоо 2014 оны 11 сарын байдлаар 30.204 (нийт 81 орноос хандалт хийгджээ) хүрсэн байна.



Клубээс гишүүддээ хандан шувуу ажиглах аяллыг хот орчимд тогтмол зохион байгуулахаас гадна, Зэрлэг амьтан судлах хамгаалах төвтэй хамтран 2010 оноос эхлэн жил бүр “Монгол орны жигүүртэн амьтад” гэрэл зургийн уралдааныг уламжлал болгон зохион байгуулж байна. Энэхүү гэрэл зургийн уралдаанд Монгол оронд авсан олон сайхан шувуудын зургууд ирдэг. Эдгээр үзэсгэлэнт шувуудын зургуудаа өөрсдийн Facebook хуудсаар нийтэлж бусад хүргэхээс гадна Байгаль орчин ногоон хөгжлийн яамны хананд байршуулж олны хүртээл болгож байгаа. МШАК энэ оноос эхлэн Таван Богд группын Улаанбаатар принт ХХК-аас сурагчидад зориулан хэвлэн гаргадаг “Мэдлэгтэй дэвтэр” бүтээл дээр нь хамтран ажиллахаар болж байгаа ба ингэснээр Монгол орны шувуудын зураг болон тэдгээрийн тухай мэдээллийг сурагчид, бага насны хүүхүүдэд шууд хүргэх боломжтой боллоо.

П.Ганхуяг, Зэрлэг амьтан судлах хамгаалах төв

Монгол орны шувуудын фото зураг – шинэ вэб сайт нээгдлээ!

Монголд шувуу ажиглагч, сонирхогчид, мөн үзэсгэлэнт шувуудын зургийг дарах сонирхолтой гэрэл зурагчдын тоо өсөн нэмэгдэхийн хэрээр Монгол орны шувуудын зураг сүүлийн жилүүдэд ихээр хуримтлагдаж байна. Үүний нэгээхэн тод жишээ нь Зэрлэг амьтан судлах хамгаалах төв болон Монголын